



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 14 эдэр

Дугаар 14

Есөнбулаг сум

**Хөрөнгө шилжүүлэхийг  
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хуучнаар Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс /орон нутгийн өмч/-т бүртгэлтэй Ландкрузер 80 маркийн ГАА 10-09 улсын дугаартай суудлын автомашиныг аймгийн Цагдаагийн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлсэн автомашиныг комисс томилон акт, бичиг баримтаар хүлээлцэн, холбогдох байгууллагуудтай хамтран хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль, журмын дагуу хийж гүйцэтгэхийг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Орон нутгийн өмчийн газар /З.Мөнхнасан/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ